



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.17 № 01/28 ДУА -2017/34/СТА -ТЦЗ

ГУРВАНСАЙХАН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Э.БОЛОРЧУЛУУН ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын Соёлын төвийн 2016 оны санхүүгийн тайландаа завсрлын аудит хийх явцад хяналтын тооллогоор 158,350.00 төгрөгийн ном дутагдсан зөрчлийг арилгах зөвлөмжийг хугацаанд нь биелүүлээгүй зөрчил илэрлээ.


Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-т /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанас хойши 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.6-д /Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дутагдсан хөрөнгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Гурвансайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Э.Болорчулуун, нягтлан бодогч Б.Энх-Амгалан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/